

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/050/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> <a href="#">www.open.audit.mn</a> Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarts@audit.gov.mn">otgonbayarts@audit.gov.mn</a> Аудитор: З.Золбоо Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:zolbooz@audit.gov.mn">zolbooz@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР  
БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

2026.02.25 № СА-2026/050/НА-СА-ТШЭ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолоор сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны 30 орон тоог баталж, тайлант онд нийт 22 ажилтан шинээр авч ажиллуулан 494,532.3 мянган төгрөгийн цалин хөлс, 59,362.8 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг олгосон байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4326050064

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус газрын нийт санхүүжилтийн 15.8 хувь буюу 324,126.2 мянган төгрөгийг нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр, гэр бүлийн хөгжил, хамгаалал гэх мэт үйл ажиллагааны төсвийг зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр бус "Бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал"-д бөөн дүнгээр баталж, зарцуулсан байгаа нь хөрөнгийн зарцуулалтад зардлын зүйл, бүлгээр тавих хяналтыг сулруулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.5 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруул-га	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө			
312	Банкинд байгаа бэлэн мөнгө			
314	Замд яваа мөнгөн хөрөнгө			
33	АВЛАГА	5		
34	УРЬДЧИЛГАА			
35	БАРАА МАТЕРИАЛ	6	79,094,613.0	96,199,150.7
351	Түүхий эд материал		2,897,210.0	6,271,210.0
3511	Тусгай зориулалттай материал		2,897,210.0	6,271,210.0
354	Хангамжийн материал		76,197,403.0	89,927,940.7
3541	Бичиг хэргийн материал		789,800.0	789,800.0
3542	Аж ахуйн материал		66,030,003.0	81,052,703.0
3544	Түлш, шатах тослох материал			1,837,337.7
3545	Барилгын засварын материал		2,978,000.0	
3547	Бусад хангамжийн материал		6,399,600.0	6,248,100.0
36	НӨӨЦИЙН БАРАА			
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		79,094,613.0	96,199,150.7
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	680,795,854.9	4,791,594,322.9
392	Биет хөрөнгө		631,293,854.9	4,771,594,322.9
39201	Барилга, байгууламж, орон сууц		596,803,135.6	4,467,803,980.0
39202	Хуримтлагдсан элэгдэл		(86,257,962.1)	
39203	Авто-тээврийн хэрэгсэл		23,500,000.0	23,500,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл		(14,197,916.9)	(17,135,416.9)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		160,426,524.3	241,506,301.6
39206	Хуримтлагдсан элэгдэл		(83,200,655.5)	(119,021,603.1)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		61,840,458.0	115,063,503.5
39208	Хуримтлагдсан элэгдэл		(34,801,635.8)	(42,145,958.1)
39214	Бусад үндсэн хөрөнгө		18,684,631.0	108,708,516.0
39215	Хуримтлагдсан элэгдэл		(11,637,723.8)	(6,820,000.0)
39217	Ном		135,000.0	135,000.0
393	Биет бус хөрөнгө		49,502,000.0	20,000,000.0
39301	Программ хангамж		563,340.0	563,340.0
39302	Хуримтлагдсан элэгдэл		(563,340.0)	(563,340.0)
39303	Бусад биет бус хөрөнгө		49,502,000.0	20,000,000.0
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		680,795,854.9	4,791,594,322.9
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		759,890,467.9	4,887,793,473.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	334,309.8	32,731,180.0
413	Өглөг		334,309.8	32,731,180.0
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		311,534.8	
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		22,775.0	9,666,680.0
4136	Бусад өглөг			23,064,500.0
41361	Байгууллагад төлөх өглөг			22,219,800.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг			844,700.0
414	Урьдчилж орсон орлого			
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10		
422	Урт хугацаат зээл			
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		334,309.8	32,731,180.0
51	Засгийн газрын хувь оролцоо		759,556,158.1	4,855,062,293.6
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		200,497,379.8	200,497,379.8
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө			
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө			

51101	Өмч: - төрийн		180,497,379.8	180,497,379.8
512	Хуримтлагдсан үр дүн		(20,381,086.4)	4,454,102,442.8
5121	Өмнөх үеийн үр дүн		(20,381,086.4)	358,596,307.3
5122	Тайлант үеийн үр дүн			4,095,506,135.5
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		579,439,864.7	200,462,471.0
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		759,556,158.1	4,855,062,293.6
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		759,890,467.9	4,887,793,473.6

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,717,217,449.9	2,472,569,706.1
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,606,673,600.0	2,294,260,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,606,673,600.0	2,294,260,300.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		110,543,849.9	178,309,406.1
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		34,585,479.9	31,865,646.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		70,323,370.0	142,523,760.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,635,000.0	3,920,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих			
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих			
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		39,547,000.0	4,685,211,168.7
120	Нийтлэг татварын бус орлого		39,547,000.0	4,685,211,168.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		39,547,000.0	4,685,211,168.7
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		39,547,000.0	4,685,211,168.7
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	1,756,764,449.9	7,157,780,874.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,731,615,478.5	2,529,447,476.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,509,412,260.1	2,176,988,250.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		927,183,303.6	1,239,188,697.4
210101	Үндсэн цалин		546,356,890.6	711,750,945.2
210102	Нэмэгдэл		281,342,412.6	307,194,012.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт		46,814,715.0	136,462,575.0
210104	Урамшуулал		52,669,285.4	83,781,164.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		116,783,834.8	149,557,796.7
210201	Тэтгэврийн даатгал		80,781,570.3	102,996,502.8
210202	Тэтгэмжийн даатгал		10,368,577.6	13,031,874.8
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,664,186.8	6,227,880.7
210204	Ажилгүйдлийн даатгал		4,164,203.7	5,449,985.1
210205	Эрүүл мэндийн даатгал		16,805,296.4	21,851,553.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		112,218,851.9	205,995,746.5
210301	Гэрэл, цахилгаан		7,175,722.6	9,992,297.2
210302	Түлш, халаалт		95,941,907.4	178,622,549.4
210303	Цэвэр, бохир ус		9,101,222.0	17,380,900.0
2104	Хангамж, бараа материалын зардал		21,210,824.0	28,455,152.3
210401	Бичиг хэрэг		3,357,000.0	7,169,750.0
210402	Тээвэр, шатахуун		2,437,526.0	12,767,762.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,942,730.0	3,097,940.0

210404	Ном, хэвлэл			1,053,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		200,000.0	220,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,030,300.0	4,146,700.0
210408	Бараа материал акталсны зардал		9,243,268.0	
2105	Нормативт зардал		426,000.0	9,758,570.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			300,000.0
210502	Хоол, хүнс			2,691,670.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		426,000.0	6,766,900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,960,710.0	8,463,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл		9,971,050.0	
210604	Урсгал засвар		1,989,660.0	8,463,000.0
2107	Томилолт, зочны зардал		286,000.0	4,296,700.0
210702	Дотоод албан томилолт		286,000.0	4,296,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		265,697,923.0	324,126,177.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		263,762,048.0	322,916,004.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		333,600.0	
210803	Даатгалын үйлчилгээ		124,675.0	
210804	Тээврийн хэрэгслийн татвар		23,600.0	59,380.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		31,600.0	33,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,422,400.0	1,000,000.0
210807	Газрын төлбөр			117,793.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		53,644,812.8	207,146,410.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,438,310.0	70,466,272.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,175,188.0	76,310,550.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		49,031,314.8	60,369,587.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		222,203,218.4	352,459,225.9
2132	Бусад урсгал шилжүүлэг		30,559,031.0	99,078,406.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал			126,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			88,998,406.4
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		29,683,531.0	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		875,500.0	9,954,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		191,644,187.4	253,380,819.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		191,644,187.4	253,380,819.5
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>			
	Дотоод эх үүсвэрээр			
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,731,615,478.5	2,529,447,476.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		25,148,971.4	4,628,333,398.7
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН			
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН			532,827,263.2
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө			532,827,263.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)			(532,827,263.2)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		25,148,971.4	4,095,506,135.5

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,717,217,449.9	2,472,569,706.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,717,217,449.9	2,472,569,706.1
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,606,673,600.0	2,294,260,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,606,673,600.0	2,294,260,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,543,849.9	178,309,406.1
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,585,479.9	31,865,646.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,323,370.0	142,523,760.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,635,000.0	3,920,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,717,217,449.9	2,472,569,706.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,717,217,449.9	2,472,569,706.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,494,418,231.5	2,119,619,980.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	941,233,141.1	1,239,188,697.4
210101	Үндсэн цалин	560,686,590.6	711,750,945.2
210102	Нэмэгдэл	281,342,412.6	307,194,012.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,814,715.0	136,462,575.0
210104	Урамшуулал	52,389,422.9	83,781,164.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,752,162.5	149,869,331.5
210201	Тэтгэврийн даатгал	81,061,432.7	103,308,037.6
210202	Тэтгэмжийн даатгал	10,057,042.9	13,031,874.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,664,186.8	6,227,880.7
210204	Ажилгүйдлийн даатгал	4,164,203.7	5,449,985.1
210205	Эрүүл мэндийн даатгал	16,805,296.4	21,851,553.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,218,851.9	205,995,746.5
210301	Гэрэл, цахилгаан	7,175,722.6	9,992,297.2
210302	Түлш, халаалт	95,941,907.4	178,622,549.4
210303	Цэвэр, бохир ус	9,101,222.0	17,380,900.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,064,150.0	51,398,200.0
210401	Бичиг хэрэг	4,459,000.0	4,843,050.0
210402	Тээвэр, шатахуун	2,406,520.0	14,247,290.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,882,730.0	3,515,540.0
210404	Ном, хэвлэл		24,907,920.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.0	200,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,115,900.0	3,684,400.0
2105	Нормативт зардал	426,000.0	12,403,162.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,938,992.4
210502	Хоол, хүнс		2,837,270.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	426,000.0	7,626,900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,517,910.0	6,260,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,510,950.0	935,000.0
210604	Урсгал засвар	4,006,960.0	5,325,000.0
2107	Томилолт, зочны зардал	286,000.0	4,412,900.0
210702	Дотоод албан томилолт	286,000.0	4,412,900.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	250,138,718.0	308,727,542.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	248,225,618.0	307,429,594.4

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	333,600.0	
210803	Даатгалын үйлчилгээ	101,900.0	22,775.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	23,600.0	59,380.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	31,600.0	33,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,422,400.0	1,065,000.0
210807	Газрын төлбөр		117,793.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,781,298.0	141,364,400.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,122,310.0	58,146,030.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,658,988.0	83,218,370.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	222,799,218.4	352,949,725.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,155,031.0	99,568,906.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		88,998,406.4
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,683,531.0	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,471,500.0	10,570,500.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	191,644,187.4	253,380,819.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	191,644,187.4	253,380,819.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	Дотоод эх үүсвэрээр		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,497,379.8	579,439,864.7	(45,530,057.8)	734,407,186.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Тайлант үеийн үр дүн			25,148,971.4	25,148,971.4
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,497,379.8	579,439,864.7	(20,381,086.4)	759,556,158.1
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			378,977,393.7	378,977,393.7
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(378,977,393.7)		(378,977,393.7)
7	Тайлант үеийн үр дүн			4,095,506,135.5	4,095,506,135.5
8	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,497,379.8	200,462,471.0	4,454,102,442.8	4,855,062,293.6

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,294,260,300.0	2,046,931,164.0	247,329,136.0	89.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,294,260,300.0	2,046,931,164.0	247,329,136.0	89.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,294,260,300.0	2,046,931,164.0	247,329,136.0	89.2
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,294,260,300.0	2,046,931,164.0	247,329,136.0	89.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,294,260,300.0	2,046,931,164.0	247,329,136.0	89.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,154,229,700.0	1,947,362,257.7	206,867,442.3	90.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,235,824,400.0	1,138,065,649.0	97,758,751.1	92.1
210101	Үндсэн цалин	733,936,300.0	664,874,085.7	69,062,214.3	90.6
210102	Нэмэгдэл	306,845,300.0	266,936,473.8	39,908,826.2	87.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	138,303,400.0	127,822,575.0	10,480,825.1	92.4
210104	Урамшуулал	56,739,400.0	78,432,514.5	(21,693,114.5)	138.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,205,700.0	137,277,057.4	19,928,642.6	87.3
210201	Тэтгэврийн даатгал	106,937,500.0	94,745,291.4	12,192,208.7	88.6
210202	Тэтгэмжийн даатгал	12,587,700.0	12,024,492.8	563,207.2	95.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,290,400.0	5,711,286.5	579,113.5	90.8
210204	Ажилгүйдлийн даатгал	6,277,800.0	4,959,197.4	1,318,602.6	79.0
210205	Эрүүл мэндийн даатгал	25,112,300.0	19,836,789.4	5,275,510.7	79.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,996,700.0	205,995,746.5	953.5	100.0
210301	Гэрэл, цахилгаан	15,149,600.0	9,992,297.2	5,157,302.8	66.0
210302	Түлш, халаалт	175,664,400.0	178,622,549.4	(2,958,149.4)	101.7
210303	Цэвэр, бохир ус	15,182,700.0	17,380,900.0	(2,198,200.0)	114.5
2104	Хангамж, бараа материалын зардал	79,902,700.0	51,398,200.0	28,504,500.0	64.3
210401	Бичиг хэрэг	14,942,500.0	4,843,050.0	10,099,450.0	32.4
210402	Тээвэр, шатахуун	17,812,000.0	14,247,290.0	3,564,710.0	80.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,539,800.0	3,515,540.0	8,024,260.0	30.5
210404	Ном, хэвлэл	24,954,300.0	24,907,920.0	46,380.0	99.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,872,200.0	200,000.0	3,672,200.0	5.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,781,900.0	3,684,400.0	3,097,500.0	54.3
2105	Нормативт зардал	16,604,900.0	12,403,162.4	4,201,737.6	74.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	997,700.0	1,938,992.4	(941,292.4)	194.4
210502	Хоол, хүнс	6,148,000.0	2,837,270.0	3,310,730.0	46.2

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,459,200.0	7,626,900.0	1,832,300.0	80.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,260,000.0	6,260,000.0		100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	935,000.0	935,000.0		100.0
210604	Урсгал засвар	5,325,000.0	5,325,000.0		100.0
2107	Томилолт, зочны зардал	5,020,900.0	4,412,900.0	608,000.0	87.9
210702	Дотоод албан томилолт	5,020,900.0	4,412,900.0	608,000.0	87.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	308,137,400.0	290,803,482.4	17,333,917.6	94.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	305,919,500.0	289,505,534.4	16,413,965.6	94.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,400.0		280,400.0	
210803	Даатгалын үйлчилгээ	123,900.0	22,775.0	101,125.0	18.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	94,100.0	59,380.0	34,720.0	63.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	53,800.0	33,000.0	20,800.0	61.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,304,600.0	1,065,000.0	239,600.0	81.6
210807	Газрын төлбөр	361,100.0	117,793.0	243,307.0	32.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,277,000.0	100,746,060.0	38,530,940.0	72.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,881,300.0	36,124,690.0	18,756,610.0	65.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	84,395,700.0	64,621,370.0	19,774,330.0	76.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,030,600.0	99,568,906.4	40,461,693.6	71.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	140,030,600.0	99,568,906.4	40,461,693.6	71.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	89,266,100.0	88,998,406.4	267,693.6	99.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,764,500.0	10,570,500.0	40,194,000.0	20.8
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг				
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,294,260,300.0	2,046,931,164.0	247,329,136.0	89.2
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2		100
3	Төсвийн байгууллага	2	2		100
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	63	48	15	76.19
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	53	38	15	71.7
8	Үйлчлэх ажилтан	9	9		100
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/
Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		172,257,722.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		172,257,722.5
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		30,345,577.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		139,112,145.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,800,000.0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		172,257,722.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ		172,257,722.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		172,257,722.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		101,123,048.4
210101	Үндсэн цалин		46,876,859.5
210102	Нэмэгдэл		40,257,539.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		8,640,000.0
210104	Урамшуулал		5,348,650.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		12,592,274.1
210201	Тэтгэврийн даатгал		8,562,746.3
210202	Тэтгэмжийн даатгал		1,007,382.0
210203	ҮОМШӨ-ний даатгал		516,594.2
210204	Ажилгүйдлийн даатгал		490,787.7
210205	Эрүүл мэндийн даатгал		2,014,763.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		17,924,060.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		17,924,060.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		40,618,340.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		22,021,340.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		18,597,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		172,257,722.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт **19,478.0** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг залрууллаа.

### Залруулсан алдаа:

1. Тайлант оны эцэст буюу 12 дугаар сарын 17-ны өдрийн А/141 дүгээр тушаалаар 1500 ширхэг “Хуулийн гарын авлага” эмхэтгэл хэвлүүлэн орлого авсан боловч үлдэгдэл 1452 ширхэг 15,972.0 мянган төгрөгийн гарын авлагыг ном, хэвлэлийн зардалд шууд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгэээ бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн болон санхүүгийн тайлангийн “*Иж бүрэн байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Орхонтуул сум дахь “Хүүхэд хөгжлийн төв”-ийн барилгад тавьж олгосон 2,978.0 мянган төгрөгийн цонх, хаалга, хөшиг, туузан гэрэл зэрэг барилгын засварын материалуудыг үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3 дугаар бүлэг:Зардал, 3.7.Тайлант үед хамаарах бараа, ажил үйлчилгээний зардлыг дараах байдлаар бүртгэнэ:(В) Бараа материал: “*Байгууллагын хэрэгцээнд бараа материал зарцуулах үед: Дт. Зардал /нэр төрлөөр/, Кт, бараа материал/нэр төрлөөр/* гэж заасныг зөрчсөн болон санхүүгийн тайлангийн “*Иж бүрэн байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Завсрын аудитаар илрүүлж, залруулсан алдаа

- Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 1,919.1 мянган төгрөгийн цалин, нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон зөрчлийг залруулсан болон Орхонтуул сумын хүүхэд хөгжлийн төвд батлагдсан багшийн орон тоонд аймгийн төвд багш авч ажиллуулсан зөрчлийг илрүүлж таслан зогсоож, тус ажилтныг ажлаас чөлөөлүүлсэн.

Аудитаар нийт **10,842.8** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 323.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 10,518.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн дүнгээс материаллаг хэмжээний зөрчлийн дүн буюу 10,842.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,473.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын автомашиныг удирдах албан тушаалтан хувьдаа хэрэглэн 323.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3 дахь "... эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан шатахууны зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## **5.2 Албан шаардлага**

5.2.1 Тайлант онд анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- "Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн чуулган, чадавхжуулах сургалт"-д хамрагдсан багш нарын ирцийг гүйцэтгэлээр бус буюу төсөвлөснөөр тооцон 520.0 мянган төгрөгийн сургалтын зардлыг санхүүжүүлсэн,
- Сэлэнгэ аймгийн хүүхдийн чуулганд томилолтоор ирж ажилласан сургагч багш, жолооч нарын албан томилолтын үнэмлэхэд гүйцэтгэх ажлын удирдамж, тайлан зэрэг анхан шатны баримтгүйгээр 2,550.0 мянган төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэл тайланд тусгасан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, шатахууныг зах зээлийн үнээс өндрөөр төсөвлөж, санхүүжүүлсэн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Тайлант онд зохион байгуулагдсан нийт 13 арга хэмжээнд зарцуулсан шатахууны зардлын нэг литр тутмыг 4030 төгрөгөөр буюу зах зээлийн үнээс 33 хувиар өндрөөр тооцон 2,948.9 мянган төгрөгийн шатахууны зардлыг олгосон ,
- Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ үзүүлэх" арга хэмжээнд зориулан 1500 төгрөгийн үнэтэй 3000 ширхэг захидал хэвлүүлж, нийт 4,500.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", 4.2.7 дахь "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.



**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			